

“ЭМ НАЙРУУЛАГЧ МЭРГЭЖИЛТНИЙ АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ БОЛОВСРУУЛАХ АСУУДАЛД” ТОЙМ ӨГҮҮЛЭЛ

*П.Мандахнаран, С.Төгсбилэг, С.Мөнхбат, С.Пүрэвсүрэн
АШУУИС, Эм зүйн сургууль*

THE NATIONAL OCCUPATIONAL STANDARDS OF PHARMACY TECHNICIAN

*Mandakhnaran P., Tugsbileg S., Munkhbat S., Purevsuren S.
Mongolian National University of Medical Sciences*

ABSTRACT

National Occupational Standards specify standards of performance that people are expected to achieve in their work, and the knowledge and skills they need to perform effectively. The National occupational standards for supporting teaching and learning in schools were developed to help improve the capacity and capability of the school workforce; they can make an important contribution to raising standards in schools.

National Occupational Standards describe best practice by bringing together skills, knowledge and values. They are valuable tools as benchmarks for qualifications as well as for defining roles at work, staff recruitment, supervision and appraisal.

Globally the roles and scope of work for technicians and pharmacy support workforce cadres vary greatly according to country and practice areas within that country. The School of Pharmacy MNUMS and Mongolian Association of Clinical Pharmacist and Association of Pharmaceutical Management has developed 4 phases National Occupational Standards.

Тойм

Зах зээлийн өндөр хөгжилтэй улс орнуудад мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас сургалтын хөтөлбөр боловсруулах, шинэчлэхэд ашиглахын тулд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг дэлгэрэнгүй тайлбарлан бичсэн баримт бичгийг боловсруулдаг. Энэ баримт бичгийг дэлхийн улс орнууд өөр өөрийнхөөрөө нэрлэдэг. Жишээ нь: Их Британид “Occupational standards”, Францад “Referentiels Professionels”, Германд “Ausbildung sordnung” гэх мэтээр нэрлээд байгаа энэхүү баримт бичгийг Монголд “Ажил мэргэжлийн лавлах” хэмээн нэрлэх нь зохистой гэж үзсэн.

Шинжлэх ухаан, техник, технологийн асар хурдацтай хөгжлийг дагаад баялаг

бүтээгч мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, тэдгээрийн ур чадварт илүү өндөр шаардлага тавигдах болсонтой уялдуулан нийгэм, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэн бэлтгэхэд мэргэжлийн түвшнийг баталгаажуулсан боловсролын баримт бичиг боловсруулах шаардлага гарсны нэг нь ажил мэргэжлийн лавлах боловсруулах юм. Ажил мэргэжлийн лавлах боловсруулах ажлыг ажил олгогчид, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагууд хамтран боловсруулж хэрэгжүүлдэг.

Эм зүйн шинжлэх ухаан түргэн хурдацтай хөгжиж, эмчилгээнд хэрэглэгдэж буй шинэ эмийн төрөл ихээр өсч, нийлэгжлийн аргаар гарган авсан хүчтэй үйлдэлтэй эм олширсонтой

холбоотойгоор эм зүйн мэргэжилтний үүрэг хариуцлагад өндөр шаардлага тавигдаж байна. Эм зүйн техникч, эм зүйн туслах ажилтны үүрэг хариуцлага, үйл ажиллагааны цар хүрээ дэлхий дахины хэмжээнд улс орон бүрт харилцан адилгүй, мөн улс оронд жигд бус байна. Иймд Эм найруулагч мэргэжилтний ажил мэргэжлийн лавлах боловсруулснаар мэргэжилтний мэдлэг, чадвар, хандлага буюу чадамжид тавигдах шаардлагыг цогц байдлаар тодорхойлдог тул боловсролын байгууллагууд сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөх үйл ажиллагаанд тулгуур баримт бичиг болохоос гадна тухайн ажил мэргэжлийн хүрээнд мэргэшлийн түвшин бүрээр ямар үүрэг, ажилбар гүйцэтгэх талаар нэгдсэн ойлголттой болсноор ажил олгогч нар ажлын байрны зар гаргах, ажилтан сонгон шалгаруулах, ажилтнаа үнэлэх зэрэгт ач холбогдолтой.

Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулах аргыг сонгохдоо тухайн улсын хөгжлийн түвшин, онцлог, хүний болон санхүүгийн нөөцийн хэмжээг харгалзаж үздэг. Эм найруулагч мэргэжлийн Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахдаа үр дүнд суурилсан сургалтыг явуулахыг гол зорилгоо болгож Ажил мэргэжлийн лавлах байхгүй тохиолдолд боловсрол, сургалтын баримт бичиг болох чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулахад ажил олгогчдыг татан оролцуулах загварыг ашигласан.

Энэ загвараар хэрэгжүүлж буй хөтөлбөрийнхөө сургалтын үр дүн (Program learning outcomes) буюу сургалтаар олгох мэдлэг, чадвар, хандлагын түвшинг урьдчилан тодорхойлж мэргэжилтний цогц чадамжийг боловсруулж батлуулсан.

АШУҮИС-ийн Эм зүйн сургууль нь ажил олгогч нар, Монголын эмнэл зүйн эм зүйчдийн хөгжил нийгэмлэг, Эм зүйн менежментийн

нийгэмлэгтэй хамтран үндэсний хэмжээнд дагаж мөрдөх (Industrial or National occupational standards) стандартыг 4 үе шаттайгаар боловсруулсан.

1. Ажил мэргэжлийн лавлах боловсруулах санаачилгыг гарган ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг нь эм найруулагч мэргэжлийн өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага, бусад адил төстэй мэргэжлээр боловсруулагдсан лавлах, ажлын байрны тодорхойлолт, мэргэжилтэнд тавигдах шаардлага, сургалтын хөтөлбөр, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт, хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгаанд үнэлгээ шинжилгээ хийсэн.

2. Ажил олгогч нартай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж эм хангамжийн байгууллагуудад ажиллах эм найруулагч мэргэжилтний гүйцэтгэх хөдөлмөрийн үүрэг ажилбарын жагсаалт, дагаж мөрдөх хууль эрх зүйн орчин, мэргэжилтэнд тавигдах шаардлага, эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлагуудыг тодорхойлсон.

3. Ажлын хэсэг нь холбогдох баримт бичиг, сургалтын хөтөлбөр, олон улсын түвшинд хэрэглэгддэг мэргэжлийн жагсаалт, ажлын чиг үүргийг үндэслэн мэргэшлийн Ү түвшинд байхыг тогтоосон.

4. Тогтоосон түвшингийн хүрээнд ажил мэргэжлийн лавлахын төслийг боловсруулан хэлэлцүүлж, санал зөвлөмжийг нь тусган, Монголын эмнэл зүйн эм зүйчдийн хөгжил нийгэмлэг, Эм зүйн менежментийн нийгэмлэгийн тэргүүлэгчдийн хамтарсан тушаалаар батлуулсан.

Ажил мэргэжлийн лавлахад Ү түвшний эм найруулагчийн ажлын байрны тодорхойлолт, ажлын байрны нөхцөл ба стандарт, хөдөлмөр эрхлэлтэд тавигдах шаардлага (эмнэлзүйн ур чадвар, эмнэлзүйн бус ур чадвар, албан

боловсрол, мэдлэг, чадвар, хандлага, хүлээх хариуцлага, мэргэжил дээшлүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэх боломж, гүйцэтгэх үүрэг ажилбарын жагсаалт)-ыг гарган батлуулсан. Энэхүү лавлах нь хөдөлмөрийн зах зээлийн тухайн үеийн хөгжлийн түвшинг тусгасан баримт бичиг тул эм зүйн салбарын хөгжил, технологийн өөрчлөлт, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, ажил мэргэжлийн онцлогоос хамааран 4-5 жил тутам шинэчлэх боломжтой.

Ном зүй:

1. Эрүүл мэндийн сайдын 2012 оны 05 сарын 18-ны өдрийн “Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг шинэчлэн батлах тухай” 183 тоот тушаал
2. National Competency Standards for Pharmacy Technicians (Entry-Level), 2015
3. Professional Competencies for Canadian Pharmacy Technicians at Entry to Practice, 2014
4. Model curriculum for pharmacy technician education and training programs, 2015
5. Монгол улсын стандарт “Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага”, MNS 5260:2015
6. Монгол Улсын стандарт “Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага”, MNS 5530:2014
7. Монгол Улсын стандарт “Биологийн идэвхт бүтээгдэхүүн ханган нийлүүлэх байгууллагад тавих шаардлага”, MNS 6396:2013
8. Монгол Улсын стандарт “Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага”, MNS 5524:2014
9. Мэргэжилтний цогц чадамж, УБ, 2019.

10. Д.Нармандах, Ажил мэргэжлийн лавлах боловсруулах аргачлал, УБ. 2015

11. Олон улсын ажил мэргэжлийн ангилал, ISCO-08

*Уншин танилцаж,
нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор, дэд профессор
Л.Уламбаяр*